Авлага дансны эхний үлдэгдэл 974.4 сая, эцсийн үлдэгдэл 1,525.0 сая төгрөг болж, 550.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	4.4	137.9	133.5
Төлбөртэй үйлчилгээний авлага			-
Татаас, санхүүжилтийн авлага		-	-
Зээлийн хүүгийн авлага	45.0	73.1	28.1
Бусад авлага	71.6	369.7	298.1
Зээлийн авлага	853.4	944.3	90.9
Дүн	974.4	1,525.0	550.6

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 2-3 жилийн насжилттай 1,017.4 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл болох 944.3 сая төгрөгийн авлага,
- Мөн дээрх сангийн зээлийн хүүгийн авлага болох 73.1 сая төгрөгийн авлага,

Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, шийдвэрлүүлэх арга хэмжээг авсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг зөрүүтэй гүйцэтгэж, татвар болон нийгмийн даатгалын байгууллагаас авах авлагын дүнг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан байна. Нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийг, татварын тайланд цалин хөлсний зардлыг зөрүүтэй тайлагнасан зэрэг алдаа, зөрчил илэрсэн. Уг алдаа, зөрчлийг холбогдох байгууллагатай тооцоо нийлж, татвар болон нийгмийн даатгалын тайланд залруулга хийх учир аудитын явцад залруулах боломжгүй байв.

- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгчидтэй 325.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

- Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 10.7 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 8.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ажиллаж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл байхгүй ба эцсийн үлдэгдэл 0.4 сая төгрөг болж, 0.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Цалингийн урьдчилгаа	-	0.4	0.4
Томилолтын урьдчилгаа	-	-	-
Дүн		0.4	0.4

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант онд үүссэн цалингийн урьдчилгаа байна. Цалингийн урьдчилгааг 2020 онд зардалд бүртгэсэн байсныг залруулж, урьдчилгаа дансанд тусгасан болно.

Аудитын илрүүлэлт:

-ЗДТГ 0.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг олгож, зардлаар бүртгэсэн байна. Үүнийг аудитын явцад залруулж, цалингийн урьдчилгаа дансанд бүртгэсэн

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,246.4 сая, эцсийн үлдэгдэл 1,530.2 сая төгрөг болж, 283.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	129.0	320.8	191.8
Бэлэн бүтээгдэхүүн	42.0	48.7	6.7
Хангамжийн материал	1,074.3	1,159.6	85.3
Мал амьтад	1.1	1.1	-
Дүн	1,246.4	1,530.2	283.8

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авч нөөцөлсөн, мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нийт 24.9 сая төгрөгийн бараа материалыг орлого болон зарцуулалтаар бүртгэхгүйгээр, мөнгөн хөрөнгийг шилжүүлэхдээ шууд зардлаар бүртгэсэн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 22,397.1 сая, эцсийн үлдэгдэл 25,303.3 сая төгрөг болж, 2,906.2 сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	18,714.0	21,319.8	2,605.80
Авто-тээврийн хэрэгсэл	179.1	158.1	-21.00
Машин тоног төхөөрөмж	726.7	804.5	77.80
Тавилга эд хогшил	720.4	717.7	-2.70
Зам, гүүрийн байгууламж	732.1	775.2	43.10
Бусад үндсэн хөрөнгө	271.1	401.6	130.50
Дуусаагүй барилга байгууламж	3.1	-	-3.10
Ном	63.7	89.5	25.80
Программ хангамж	3.1	15.3	12.20
Бусад биет бус хөрөнгө	983.8	1,021.6	37.80
Дүн	22,397.1	25,303.3	2,906.2

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 174.7 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 182.3 сая, хандиваар авсан 8.5 сая төгрөгөөр, улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ш ашиглагч байгууллага бүртгэж, 3,588.1 сая төгрөгөөр, нийт 3,953.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлсэн 97.1 сая, акталсан 87.9 сая төгрөгөөр, нийт 185.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь үндсэн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн бүртгэхдээ хуримтлагдсан элэгдлийг бүртгээгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 59.2 сая, эцсийн үлдэгдэл 478.1 сая төгрөг болж, 418.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	59.2	593.5	534.3	100
Ажилчидтай холбогдсон өглөг	1.2	17.4	16.2	2.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг		111.9	111.9	18.9
Байгууллагад төлөх өглөг	57.5	463.1	405.6	78.0
Хувь хүмүүст төлөх өглөг	0.5	1.1	0.6	0.2
Нийт дүн	59.2	593.5	534.3	100

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ажилчидтай холбогдсон өглөг 17.3 сая төгрөг байна. Энэ нь цалингийн тооцоолол, төсвийг буруу тооцож, холбогдох байгууллагад нийгмийн даатгалын шимтгэлийг, хамтын санд хуримтлалыг шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Бараа, үйлчилгээний зардлын өглөгийн үлдэгдэл 111.9 сая төгрөг байгаа нь нэгтгэлд хамрагдсан 3 байгууллагын төсөв хүрэлцээгүйгээр түлш, халаалтын өглөг үүссэн байна. Байгууллагад төлөх өр төлбөрийн үлдэгдэл 463.1 сая төгрөг байгаа нь орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 347.2 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ны санхүүжилтийн үлдэгдэл 115.3 сая төгрөг байна. Сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас хөрөнгө оруулалтын ТАХ-г бүрэн санхүүжүүлэх боломжгүй болсон байна.

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 6.7 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 12.6 сая төгрөгийн, соёл спортын ордон 67.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй ажиллаж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 25,372.5 сая, эцсийн үлдэгдэл 28,762.4 сая төгрөг болж, 3,389.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	6,807.5	6,704.8	-102.7	23.4
Хуримтлагдсан үр дүн	13,868.9	17,245.9	3,492.3	60.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,696.1	4,696.4	0.3	16.4
Дүн	25,372.5	28,647.1	3,274.6	100.0

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 28,762.4 сая төгрөг болж, 3,389.9 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оруулсан капитал данс 102.7 сая төгрөгөөр буурсан нь тус сумын багийн алба нь 2015 оноос өмнө санхүүгийн тайлан гаргаж байгаад 2015 онд төсөв, санхүүгийн тайлан нь ЗДТГ-т санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна. Тус багийн албаны Засгийн газрын оруулсан капитал данс нь 102.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг 2020 онд хааж, бүртгэсэн байна.

3.5.10 Орлогын данс

Тайлант онд нийт 16,905.0 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнд, татварын орлого 1,753.5 сая төгрөг, татварын бус орлого 4,786.5 сая төгрөг, үндсэн болон нэмэлт санхүүжилтийн орлого 10,365.1 сая төгрөгийн орлогыг бүртгэсэн байна.

Татварын 8 төрлийн орлогыг бүрдүүлж ажилласан байна. Татварын бус орлогод хүү, торгуулийн орлогоос 728.4 сая төгрөг, бусад татварын бус орлогоос 32.8 сая төгрөг, сум хөгжлийн сангийн зээлийн хүү болон алдангийн орлогоос 36.2 сая төгрөг, байгууллагын ахмадын санд шилжүүлсэн 5.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 14.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн ба үнэ төлбөргүй 3,725.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 244.0 сая төгрөгийн бараа материалыг орлогод тусгасан байна.

Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 7,640.6 сая төгрөг, ОНХС-ийн шилжүүлгээр 428.9 сая төгрөг, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардалд 1,193.9 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагын урсгал зардалд 43.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр урсгал зардалд 1,057.8 сая төгрөг, нийт 10,365.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Аудитын илрүүлэлт:

-Захирагчийн ажлын алба нь тогтмол шинж чанартай, давтагдах шинжтэй 5.9 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Уг орлогыг туслах үйл ажиллагааны орлогод төлөвлөн, зарцуулж байх тухай зөвлөмжийг урьд оны аудитаар өгсөн боловч одоог хүртэл хэрэгжээгүй байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд нийт 13,096.9 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд, үйл ажиллагааны зардлын дүн 13,074.7 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардлын дүн 22.2 сая төгрөг байна. Нийт зардалд материаллаг хэмжээний цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал /58.2 хувь/, байр, ашиглалттай холбоотой тогтмол зардал /10.5 хувь/, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал /7.4 хувь/ байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 3.5 сая төгрөгийг, 1 дүгээр цэцэрлэг 0.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

- Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэг батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллаж, 1.3 сая төгрөгийн цалингийн зардлыг зарцуулсан байна.

- Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэг нийгмийн даатгалын тайланд цалингийн зардлыг 0.5 сая төгрөгөөр илүү тайлагнаж, нийгмийн даатгалын байгууллагад шимтгэлийг илүү төлсөн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 14/05 дугаар тогтоолд зааснаар Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 3,925.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан. Сумын ИТХ-ын тогтоолд төвлөрүүлэх орлогын дүнг 1,711.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 5,381.5 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 2,514.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 2,867.1 сая төгрөгөөр тасалсан байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	950.0	789.6	160.4	83.1%
2	Хадгаламжийн хүүгийн орлого	316.8	431.9	(115.1)	136.3%
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	62.0	169.6	(107.6)	273.6%
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	49.6	30.1	19.6	60.6%
5	Галт зэвсгийн албан татвар	2.8	2.8	(0.004)	100.1%
6	Улсын тэмдэгийн хураамж	1,671.4	266.7	1,404.7	16.0%
7	Хог хаягдлын хураамж	40.3	53.6	(13.3)	133.0%
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал	5.5	8.9	(3.4)	161.9%
9	Хүү торгуулийн орлого	1,976.9	728.4	1,248.6	36.8%
10	Нэр зааж ангилагдаагүй орлого	304.2	32.8	271.4	10.8%
11	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2.0	-	2.0	0.0%
НИЙТ		5,381.5	2,514.3	2,867.1	46.7%

Эх сурвалж: Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 5 нэр төрлийн орлого 239.4 сая төгрөгөөр давж, 6 нэр төрлийн орлого 3,106.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд,

- Хадгаламжийн хүүгийн орлого 115.1 сая төгрөгөөр давсан нь хадгаламж эзэмшигчийн тоо нэмэгдсэн болон иргэдийн хадгаламжийн хэмжээ өссөнөөс шалтгаалсан байна.
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 107.6 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгөөнд тусгагдаагүй, эх орны хишиг, ноос, арьс ширний урамшууллаас татвар суутгасан,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 13.3 сая төгрөгөөр давж биелсэн нь айл өрхийн хог хаягдлын хураамжийг БЗӨБЦТС-тай гэрээ байгуулан цахилгааны төлбөрийн хамт төвлөрүүлдэг болсонтой холбоотой байна.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд,

- Үй ажиллагааны орлого 160.4 сая төгрөгөөр тасарсан нь улсын хил цар тахлын улмаас тайлант оны 1 дүгээр сард хаагдаж, улс хоорондын зорчигч тээвэр болон сумын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхэлдэг явуулдаг иргэдийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.
- Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 19.6 сая төгрөгөөр тасарсан нь цар тахлын улмаас иргэдийн орлого буурч, үл хөдлөх хөрөнгө худалдан авалт багассан.

- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,404.7 сая төгрөгөөр тасарсан нь улсын хилээр нэвтрэх гадаадын иргэдийн зорчих хөдөлгөөн зогссонтой холбоотойгоор Гадаадын иргэн, харьяатын газраас төвлөрүүлдэг хураамжийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Хүснэгт №9. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн орлого	2,151.1	184.5	1,966.6	8.5

Замын-Үүд сумын төсөв захирагчаас аймгийн төсөвт 2,151.1 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 184.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.5 хувиар биелүүлсэн байна. Орлогыг 1,846.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь тухай сумын татварын болон татварын бус орлого 2,867.1 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,425.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,761.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс орлогыг 3,499.7 сая төгрөгөөр бууруулж, 3,925.4 сая төгрөгөөр, зардлыг 1,988.0 сая төгрөгөөр бууруулж, 1,773.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 13,045.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12,352.6 сая төгрөгийг урсгал зардалд, 428.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, сум хөгжүүлэх сангаас олгох зээл болон нөхөн сэргээлтийн тусгай данснаас зарцуулах нөхөн сэргээлтийн ажилд 263.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 8,238.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 4,541.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 265.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,069.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 3,404.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 43.9 сая төгрөгийг, нийт 11,517.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 1,305.6 сая төгрөгийн санхүүжилтийг улс болон орон нутгийн төсвөөс дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 77.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 187.8 сая төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн орлого 184.7 сая, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх орлого 1.1 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 2.0 сая төгрөгөөр тасарснаас шалтгаалжээ. Төсөвт байгууллагын харьяа 3 ахмадын санд нийт 3.7 сая төгрөг, өрхийн эмнэлгийн дансанд туслах үйл ажиллагааны орлого 13.9 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,287.9 сая төгрөг буюу 86.5 хувьтай /1,757.1 сая төгрөгийн хэмнэлттэй/ байгаа нь санхүүжилтийг 1,305.6 сая төгрөгөөр дутуу олгосон, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг 101.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгийг 120.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, зарим байгууллагын урсгал зардлын төсөв 229.3 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалсан байна. Нийт зардал 86.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах зардлууд хэмнэгдсэн болон дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон НДШ-ийн зардал 268.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь байгууллагуудад нийт 4 орон тоо сул байсан, сургуулийн хичээл ороогүйгээс багш нарт олгох илүү цагийн хөлс хэмнэгдсэн, мөн цалингийн төсөв хүрэлцээгүйгээс шалтгаалсан байна.

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 284.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь түлш халаалтын зардал 212.9 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардал 43.9 сая төгрөгөөр, цэвэр бохир усны зардал 27.7 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Энэ нь санхүүжилт дутуу олгогдсоноос нийт 9 сургууль, цэцэрлэгийн тогтмол зардал 114.4 сая төгрөгөөр, соёл, спортын ордны тогтмол зардлын төсөв 105.2 сая төгрөгөөр, ЗДТГ-ын төсөв 64.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.
- Хүүхдийн хоолны зардал 239.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь цар тахлын улмаас сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.
- Хөрөнгө оруулалтын зардал 628.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь ОНХС-ийн 120.3 сая төгрөгийн санхүүжилтийг ТАХ гүйцэтгэгч байгууллагад бүрэн шилжүүлээгүйтэй холбоотой байна. Сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажил 507.8 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт бүрэн олгогдоогүйтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 225.8 сая төгрөгийг улсын, 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээнд 1,267.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 639.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. ОНХС-ийн хөрөнгийг гүйцэтгэгч байгууллагад бүрэн шилжүүлээгүйгээс 115.3 сая төгрөгийн өр төлбөр, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажилд санхүүжилт дутуу олгогдсоноос 347.2 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 754.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 356.5 сая, нийт 1,111.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 8.9 сая, эд хогшил худалдан авахад 17.6 сая, томилолтын зардалд 3.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 827.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 206.9 сая, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 1.5 сая, нийт 1,066.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 44.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 174 мэдээллээс 165 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал, сумын Засаг даргын 4 захирамжийг огт байршуулаагүй, тендерийн ерөнхий мэдээллийг 4 болон 8 дугаар саруудад хугацаа хоцроож байршуулсан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг 10 дугаар сард хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 17 төсвийн байгууллага, 2 тусгайн сан, 3 ахмадын сан, 1 орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн санхүүгийн тайлан, 1 тусгай данс, 1 хөрөнгө оруулалтын дансны нийт 25 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага, сан түүврээр хамрагдсан байна. Замын-Үүд сумын 7 дугаар цэцэрлэг нь 2020 оны 10 дугаар сард ашиглалтад орсон учир аудитад хамрагдах байгууллагын жагсаалтад ороогүй байна. Сургуулийн ахмадын сан, нөхөн сэргээлтийн тусгай данс, хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулаагүй, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ болон холбогдох ТШЗ-дын санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 9 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба зөрчилтэй дүгнэлт авсан байгууллага үгүй болно.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд алдаа, зөрчил илрээгүй ба залруулга хийгдээгүй, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 856.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 484.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 329.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлж, 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 41.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүлж, 0.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчтэй авлагын тооцоо нийлээгүй 325.0 сая төгрөгийн зөрчилд тус сангийн аудитыг гүйцэтгэх явцад албан шаардлага хүргүүлсэн. Уг зөрчлийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад арилгасан учир ТТЗ-ын аудитын тайланд зөрчилд тооцсон боловч, аудитын явцад залруулсан учир дүгнэлт гаргахад зөрчлийн дүнд нөлөөлөхгүй гэж үзлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц болон дараагийн аудитаар авч үзэх асуудал илрээгүй болно.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

4.1. Орон нутгийн орлого төлөвлөлттэй холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт

Тайлант онд тус сумын орон нутгийн орлогод төвлөрүүлэх орлогын хэмжээг аймгийн ИТХ-аас 3,925.4 сая төгрөгөөр хянасан ба үүнийг сумын ИТХ-аас 1,456.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 5,381.5 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 2,514.3 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 2,867.1 сая төгрөгөөр тасалсан байна. Нийт 5 төрлийн орлогыг 239.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол 6 төрлийн орлогыг 3,106.6 сая төгрөгөөр тасалсан байна. Сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл, орлого төлөвлөсөн мэдээлэлд үндэслэн хянахад хог хаягдлын үйлчилгээний хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

4.1.2 Эрсдэл

Орлогын төлөвлөгөөтэй уялдуулан зардлыг үндэслэлгүйгээр төлөвлөх, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх

4.1.3 Өгсөн зөвлөмж

Хог хаягдлын үйлчилгээний хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, татварын болон татварын бус орлого төлөвлөлттэй холбоотой баримт материал, тоон мэдээллийг сумын ИТХ-д өргөн мэдүүлэх төсвийн төслийн танилцуулгад тодорхой тусгах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Хариу тайлбар ирүүлээгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020 он

Аудитын нэр:

Замын-Үүд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мянган төгрөгөөр

Аудитын код:

ДГА-2021/5/СТА-ТТЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

Замын-Үүд сумын төсвийн төвлөрүүлэн захирагч

№	Төсвийн шууд захирагч	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийх хэлбэр	Санал, дүгнэлтийн хэлбэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
							Албан тушаал	Овог нэр
A		1	2	3			4	5
1	Замын-Үүд сумын ЗДТГ	Цалингийн урьдчилгааг олгоод суутгаагүй	300.0	Төлбөрийн акт тогтоох	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Б.Батдулам, Н.Тунгалаг
2		Шилэн дансны системд 138,520.3 мянган төгрөгийн 18 гүйлгээг байршуулаагүй		Албан шаардлага өгөх				
3		Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	3,543.8	Албан шаардлага өгөх				
4		НДШ, ХХОАТ-ын тайланд тусгагдан цалин хөлс болон суутгалын дүн зөрүүтэй		Албан шаардлага өгөх				
5		Нийт 24,896.2 мянган төгрөгийн бараа материалын гүйлгээг анхан шатны баримтат үндэслэн бүртгээгүй, орлого, бараа материалыг бүртгэхгүйгээр шууд зардалд тусгасан		Зөвлөмж өгөх				
6		Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг зөрүүтэй тусгасан	10,808.0	Аудитын явцад залруулсан				
7		Хамтын санд шилжүүлэх хуримтлалыг албан хаагчдаас суутгаж авсан боловч, шилжүүлээгүй ба үүнийг тайланд өглөгөөр бүртгээгүй байна	2,466.6					
8		Цалингийн урьдчилгаа болон цалингаас суутгасан хамтын сангийн мөнгийг НББ-д буруу тусгасан.	6,170.1					
9		Харилцагч байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ шууд зардалд тусгасан, тооцооны дансанд бүртгээгүй байна.	134,590.5					
10	Замын-Үүд сумын ИТХ	2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс илүү олгосон мөнгийг төлүүлэх тухай 751.0 мянган төгрөгийн төлбөрийн акт хэрэгжээгүй	751.0	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлэх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Ажлын албаны дарга, нягтлан бодогч	А.Анхтуяа, Н.Тунгалаг
11		Урсгал үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг анхан шатны баримт болон журналаас шүүж төсвийн гүйцэтгэлтэй тулгахад оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн дэмжлэгт /сургалтын төлбөр/ 9992.0 сая төгрөг, ИТХ-ын хуучин, шинэ төлөөлөгчдийн хүндэтгэлийн арга хэмжээнд 7671.7 мянган төгрөг, Түмэн-Од хөл бөмбөгийн клубт дэмжлэг 500.0 мянган төгрөг, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтгүйгээр суудлын авто машинд 2776.0 мянган төгрөгийн 4 дугуй авсан зэрэг нийт 20939.7 мянган төгрөг зарцуулсан байна.	-	Зөвлөмж өгөх				

№	Төсвийн шууд захирагч	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийх хэлбэр	Санал, дүгнэлтийн хэлбэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
							Албан тушаал	Овог нэр
12	Замын-Үүд сумын ИТХ	Мобикомд корпрацид 1000.0 сая төгрөгийг шуудан холбоо, интернетийн төлбөрийн зардлаас шилжүүлсэн, зардал гарсан тухай холбогдох анхан шатны нотлох баримт байхгүй байна. Үүнд авлага үүсгэж бүртгээгүй байна.	1,000.0	Аудитын явцад залруулсан	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Ажлын албаны дарга, нягтлан бодогч	А.Анхтуяа, Н.Тунгалаг
13		Санхүүгийн байдлын тайлангийн ажилчидтай холбогдсон өглөгийн үлдэгдэл хасах 395075 төгрөгөөр илэрхийлэгдсэн	395.1	Аудитын явцад залруулсан				
14		Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлын дүн 72469.7 мянган төгрөг, ҮДТ-нд 76238.6 мянган төгрөгөөр тайлагнагдсан ба цалингийн зардлын дүнг 3768.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.	3,768.9	Аудитын явцад залруулсан				
15	ЗАА	Ажиллагсдын цалингийн карт, сар бүр цалин бодсон цалингийн тооцооны хүснэгт, мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлангийн цалингийн зардлын дүнгүүд зөрүүтэй байна.	2,586.1	Аудитын явцад залруулсан	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Ажлын албаны дарга, нягтлан бодогч	Ц.Саруулсайхан, Н.Тунгалаг
16		НДХ-т төлсөн НДШ ерөнхий журналын дүн 12756.0 мянган тхирсон, харин НДШ-ийн зардал ҮДТ, МГТ-ийн тайланд 2586.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	2,586.1	Аудитын явцад залруулсан				
17		Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд цахим тендерийн хураамжийн орлого 5938.4 мянган төгрөг орсон бөгөөд үйл ажиллагааны орлогоор төлөвлөж төсөв батлуулаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж биелэгдээгүй байна.	-	Албан шаардлага өгөх				
18		461.5 мянган төгрөгийн 1 актыг барагдуулсан, 7876.0 мянган төгрөгийн 2 хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Зураг төсөв, агаарын шугамын асуудлыг шийдвэрлүүлээгүй байна.	-	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлэх				
19	ОНХС	Санхүүгийн тайланд авлага өглөгийг тусгаагүй байна.	230,503.9	Аудитын явцад залруулсан	Хэсэгчлэн аудит хийх	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Анхбаяр, Н.Тунгалаг	
20	СХС	Санхүүгийн тайланд СХС-ийн Зээлийн авлагыг илүү, Зээлийн хүүгийн авлагыг дутуу тооцоолсон байна.	37,367.9	Аудитын явцад залруулсан	Хэсэгчлэн аудит хийх			
21		Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	324,972.1	Албан шаардлага өгөх				
22	Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэг	Элэгдлийн тооцоолол буруу хийгдсэн	1,097.1	Аудитын явцад залруулсан	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Эрхлэгч	Ц.Сүглэгмаа
23		Батлагдсан орон тоо хэтэрсэн	1,292.4	Зөвлөмж өгөх				
24		Цалингийн зардлаа НД-ын байгууллагад 382.3 мянган төгрөгөөр илүү тайлагнаснаар НД-ын байгууллагад 91.7 мянган төгрөгийн шимтгэл илүү төлөгдсөн байна.	474.0	Зөвлөмж өгөх				
25		Төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	577.2	Албан шаардлага өгөх				
26	Замын-Үүд сумын 2 дугаар цэцэрлэг	ҮХ-ийн тайлан хугацааны элэгдлийг давтан тооцоолоход 38.8 сая төгрөгийн зөрүү үүссэн.	38,835.1	Аудитын явцад залруулсан	Хэсэгчлэн аудит хийх	Эрхлэгч	Н.Отгонтөгс	
27	Замын-Үүд сумын 3 дугаар цэцэрлэг	Данс хооронд хөрөнгө ангилж шилжүүлэхдээ ХЭ-ийг хамтад нь шилжүүлээгүй байна	-	Зөвлөмж өгөх	Хэсэгчлэн аудит хийх	Эрхлэгч	И.Ган-Эрдэнэ	

№	Төсвийн шууд захирагч	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийх хэлбэр	Санал, дүгнэлтийн хэлбэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
							Албан тушаал	Овог нэр
28	Замын-Үүд сумын 4 дүгээр цэцэрлэг	Орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн, буцаан авах нэмэлт орлогыг авлагаар бүртгээгүй	498.3	Аудитын явцад залруулсан	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Эрхлэгч	Н.Сүхтоогоо
29		ХХОАТ-704,4 НДШ-85.3 мянган төгрөгөөр илүү суутгасан.	789.6	Аудитын явцад залруулсан				
30		Акталсан бараа материалын дансны бичилт алдаатай	78.4	Аудитын явцад залруулсан				
31		Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцсон	11,316.0	Аудитын явцад залруулсан				
32	Замын-Үүд сумын 6 дугаар цэцэрлэг	ҮХ нэмэгдсэн, хасагдсантай холбоотой тушаал шийдвэрүүдийг бүрэн ирүүлээгүй, элэгдлийн зардлыг давтан тооцоолоход зөрүүтэй байна. Учир нь 2019 онд ашиглалтад авсан хөрөнгүүдэд элэгдэл тооцоогүй.	-	Албан шаардлага өгөх	Хэсэгчлэн аудит хийх		Эрхлэгч	Л.Юмжирмаа
33	Замын-Үүд сумын 1 дүгээр сургууль	Тайлант хугацаанд өр, авлага үүсгэсэн	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Захирал	А.Сүрэнхүү
34	Замын-Үүд сумын 2 дугаар сургууль	Тайлант хугацаанд авлагатай ажилласан	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Захирал	Т.Баттуяа
35	Замын-Үүд сумын Борхойн наран өрхийн эмнэлэг	Иргэд, ААН байгууллагаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е-баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/	39,916.4	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Дарга	Б.Буянхишиг
36	Соёл, спортын төв	Тайлант хугацаанд өр, авлага үүсгэсэн	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Дарга	Г.Батзаяа
37	ТТЗ	Сумын татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Засаг дарга, Санхүү, төрийн сангийн тасгийн дарга	Б.Анхбаяр, Ш.Сувд-Эрдэнэ
НИЙТ			856,684.6					